

Эх сурвалж:

А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: munkhjargal6lgy@moes.edu.mn Утас: 89336089

**ДОРНОД АЙМГИЙН 2026 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Боловсролын газар

2026.06.20

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээний үндсэн зорилго нь салбарын хэмжээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр тус бүрийн одоогийн явц, хүрсэн үр дүн болон зорилтот түвшний гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд оршино. Үүний зэрэгцээ хэрэгжилтийн явцад тулгарч буй хүндрэл бэрхшээл, эрсдэлийг эрт үед нь илрүүлж, жилийн эцэст төлөвлөсөн ажлуудыг бүрэн дүүрэн биелүүлэхэд чиглэсэн удирдлагын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэгдсэн болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам” баримтлав.

ХОЁР. ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Дорнод аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 үндсэн чиглэлийн 15 арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар нэгдсэн дүнгээр тооцож үзэхэд нийт дундаж хэрэгжилт 86.3 хувьтай буюу үр дүнтэй гэж үнэлэгдлээ.

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Үр дүнтэй (85% дээш)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84%)	Үр дүн хангалтгүй (30-59%)	Үр дүн гараагүй (0-29%)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Үнэлгээ /хувь/
1	Хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг багасгах зорилт, арга хэмжээ	3	2		1			80 Үр дүн хүлээгдэж байгаа
2	Суралцагчдын мэдлэг, чадвар, авьяасыг дэмжих зорилт, арга хэмжээ	5	4	1				92 Үр дүнтэй
3	Багш, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах зорилт, арга хэмжээ	1	1					100% Үр дүнтэй
4	Хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулах зорилт, арга хэмжээ	1	1					100% Үр дүнтэй
5	Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн	6	3	2	1			81.5 Үр дүн хүлээгдэж байгаа

Эх сурвалж:

А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: munkhjargal6lgy@moes.edu.mn Утас: 89336089

	хүртээмжийг нэмэгдүүлэх							
	НИЙТ	16	13	3	2			86.3 Үр дүнтэй

ГУРАВ. ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Төлөвлөгөөний чиглэл тус бүрээр авч үзвэл,

- Хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг багасгах хүрээнд Хэрлэн сумын 7 сургуулийн ариун цэврийн өрөөний 190 ширхэг тусгай тоноглол болон Баяндун сумын Хүүхдийн хөгжлийн танхимын тохижилт 100 хувь дуусчээ. Мөн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хувилбарт сургалтын “Гэрт хүрэх багц” төслийн худалдан авалт зорилтот түвшиндээ хүрч 100 хувиар үнэлэгдсэн бол залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн бэлтгэл ажил хангагдаж 40 хувийн явцтай байна.
- Суралцагчдыг дэмжих чиглэлээр 23 сургуулийн 2200 сурагчийг хамруулсан "Хүн болох багаасаа" гадаад хэлний төслийн багш нарын хуваарилалт, зохион байгуулалт болон 12-р ангийн сурагчдад зориулсан 5 удаагийн онлайн сорил, 31 удаагийн зөвлөмж бичлэг амжилттай хүргэгдэн зорилтот түвшиндээ хүрч тус тус 100 хувиар үнэлэгдлээ. “Гэртээ туршья” аянд нийт 2860 хүүхэд хамрагдан, Хэрлэн сумын 8-р сургуулийн байгалийн ухааны кабинетыг 25 сая төгрөгөөр бүрэн шинэчлэн, 23 сургуульд физикийн туршилтын багаж хэрэгслээр нийлүүлж, Улсын физикийн 37-р олимпиадыг Чойбалсан хотноо 200 сая төгрөгөөр маш амжилттай зохион байгуулсан ажлууд бүгд 100 хувийн биелэлттэй байна. Ерөнхий боловсролын 5 сургуулийн суралцагчдын урлаг, гоо зүйн танхимын тоног төхөөрөмж, орчныг сайжруулахаар төлөвлөсөн ч 2 сургуульд хэрэгжүүлсэн тул хэрэгжилтийг 60 хувиар үнэлэв.
- Багш, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр мөн адил 100 хувийн биелэлттэй гарсан бөгөөд 23 багшид орон сууцны урьдчилгаа 20 сая төгрөгийн дэмжлэгийг олгож, салбарын хэмжээнд дэмжлэг авсан багш нарын нийт тоог 88-д хүргэснээс гадна тэргүүлэх зэрэгтэй багш нар 74-өөр нэмэгдэж хагас жилийн зорилтот түвшиндээ хүрчээ.
- Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулах ажил 100 хувь биелж, ОНХС болон ОУБ-ын дэмжлэгээр сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийн хангамж зорилтот түвшинд хүрсэн.
- Техник, тоног төхөөрөмжийн хүртээмжийн хувьд цахим ангийн 22 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх, Халхгол сумын сургуулийн дотуур байрны тохижилт болон НҮБ-ын Хүүхдийн сангийн таблетын хангамжийн ажлууд 100 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга угсралтын ажил 77 хувь, их засварын ажил 62 хувь, Дашбалбар сумын сургуулийн спорт заалны ариун цэврийн байгууламжийн ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДӨРӨВ. ЭРСДЭЛТЭЙ БОЛОН АНХААРАЛ ХАНДУУЛАХ АСУУДЛУУД

Эх сурвалж:

А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Емэйл: munkhjargal6lgv@moes.edu.mn Утас: 89336089


Хяналт-шинжилгээний явцад төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй хэд хэдэн анхаарал татсан хүндрэлтэй асуудлууд илэрлээ. Үүний гол шалтгаан нь барилга угсралт, их засварын ажлуудын худалдан авах ажиллагаа удаашралтай байгаатай холбоотой бөгөөд тухайлбал барилга угсралтын 4 ажил, их засварын 6 ажил, мөн Дашбалбар сумын сургуулийн ариун цэврийн байгууламжийн ажил өнөөдрийг хүртэл гэрээ байгуулах шатандаа үргэлжилж байгаа нь хугацаа алдах эрсдэлийг үүсгэж байна. Нэн ялангуяа, Цагаан-Овоо сумын дотуур байрны барилга угсралтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байгаа хэдий ч гүйцэтгэгч талтай холбоотой асуудлаас шалтгаалан гэрээ цуцлах шатанд орсон нь салбарын хэмжээнд хамгийн том тулгамдсан асуудал болоод байна. Эдгээр барилга, засварын ажлууд цаг хугацаандаа эхэлж чадахгүй удирдамжийн дагуу сунжрах нь жилийн эцсийн нэгдсэн үнэлгээг доош татах, сурагчдын сурч боловсрох ая тухтай орчин хагас жилээр саатах эрсдэлийг дагуулж байна.

ТАВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцэст бүрэн 100 хувьд хүргэхийн тулд удирдлагын түвшинд шуурхай зохицуулалт хийх шаардлагатай байна.

1. Худалдан авах ажиллагааны газартай хамтран гэрээ байгуулах шатанд байгаа 10 гаруй их засвар болон барилгын ажлын гэрээг 2026 оны 7 дугаар сард багтаан эцэслэх. Одоо хүртэл гэрээ байгуулах шатанд яваа барилга угсралтын 4 ажил болон их засварын 6 ажлыг яаралтай эцэслэн шийдвэрлэж, гүйцэтгэгчдийг ажлын талбарт гаргах бэлтгэлийг цаг алдалгүй хангах
2. Цагаан-Овоо сумын дотуур байрны барилгын ажил (85%-ийн гүйцэтгэлтэй) гэрээ цуцлах шатанд орсон тул дараагийн гүйцэтгэгчийг яаралтай сонгон шалгаруулах
3. Гүйцэтгэл нь 30-40 хувьтай байгаа барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд анхаарах
4. Бэлтгэл ажил нь хангагдаж буй залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ АРГА ЗҮЙЧ

 А.МӨНХЖАРГАЛ